

## **МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

### **Захиалагч:**

Монгол Улсын Хөгжлийн банк, Эдийн засаг, Хөгжлийн яам

### **Гүйцэтгэгч:**

Монгол Улсын Хөгжлийн банкны Захиргаа удирдлагын газар, Хуулийн хэлтэс

**Улаанбаатар хот 2025 он**

## **АГУУЛГА**

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

Хоёр. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцооны тайлан:

- 2.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2. Нэг бүрийн зардлыг тооцох;
- 2.3. Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 2.5. Хялбарчлах боломжийг шалгах;
- 2.6. Нэмэлт зардлыг тооцох.

Гурав. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцооны тайлан:

- 3.1. Шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;
- 3.2. Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- 3.3. Нийт хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох
- 3.4. Бусад зардал;
- 3.5. Зардлыг нэгтгэн тооцох;
- 3.6. Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

**Дөрөв. Дүгнэлт, санал**

# **ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

/Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн  
шинэчилсэн найруулгын төсөл/

## **Нэг. Ерөнхий мэдээлэл**

### **1.1. Судалгааны арга зүй:**

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл<sup>2</sup> /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдснаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх-/ыг баримтлан доорх зардлын тооцоог хийв.

Хуулийн төсөл батлагдснаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хуулийн төслийн зохицуулалтаар буюу хуулийн төсөл батлагдснаар зардал тээгч хуулийн этгээд, төрийн байгууллагад тодорхой зардал үүсгэхээр байна. Харин иргэнд зардал үүсэхээргүй байна.

Хуулийн төслөөс хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлоходоо уг хуулийн төсөл нь шинэчилсэн найруулга хэлбэрээр бичигдэж байгаа тул уг хуулийн төслөөр зохицуулах харилцааг одоогоор зохицуулж буй 2017 онд батлагдсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд тусгагдаагүй шинээр гүйцэтгэх үүргийн хүрээнд хязгаарласан болно.

Хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдол нилээд байсан тул аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээг байгаа эсэхийг судалж, баримжаалах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

### **1.2. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай ерөнхий мэдээлэл**

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 195 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “МУХБ” гэх) байгуулахаар шийдвэрлэж байсан.

<sup>1</sup> Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Тус зардлын тооцооны тайланг гүйцэтгэхдээ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдын хамтран баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн үзэл

МУХБ-ны тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталж, банкны эрх зүйн байдлыг “Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна” гэж тодорхойлсон.

“Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг ЗГХЭГ 2016 оноос эхлэн хэрэгжүүлж байсныг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 122 дугаар тогтоолоор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж байгаад Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 25 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж эхэлсэн байна.

Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсанаас хойш ТУЗ-ийн даргаар нийт 11 хүн буюу дунджаар 1.6 жил ажиллаж байна. Ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 51 өдөр, их нь 1404 өдөр буюу ажиллажээ. Ажиллаж байсан 10 хүний 5 нь дунджаар 230 хоног, 3 нь дунджаар 650 хоног, 2 нь 1000-аас дээш хоног ажилласан байна.

ТУЗ-ийн гишүүнээр нийт 30 орчим хүн ажиллаж байснаас ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 110, их нь 1404 өдөр ажилласан ба дунджаар 673 хоног ажилласан байна. Нийт 25 гишүүний 24 хувь нь 1 жил хүртэл хугацаанд ажилласан бол үлдсэн 76 хувь нь 1-3.8 жил хүртэл хугацаагаар тус тус ажиллажээ.

ТУЗ-ийн хараат бус гишүүдээр нийт 20 гаруй хүн ажилласнаас ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 73, их нь 2069 өдөр ажилласан ба 16 хүн дунджаар 791 хоног ажилласан байна. Ажиллаж байсан 16 хүний 12.5 хувь нь 1 жил хүртэл хугацаанд ажилласан бол үлдсэн 87.5 хувь нь 1-ээс 5.6 жил хүртэл ажилласан байна.

Гүйцэтгэх захирлаар нийт 8 хүн томилогдсоноос хугацааны хувьд хамгийн бага нь 217, их нь 1106 өдөр ажилласан ба дунджаар тус албан тушаалд 667 хоног ажилласан байна.

Тэргүүн дэд болон дэд /орлогч/ захирал, газрын захирлаар нийт 30 гаруй хүн ажилласнаас тайлант хугацаанд 7 хүн томилогдсон өдрөөс хойш ажиллаж байна. Тодруулбал, 2013 оноос хойш эхлэн ажиллаж байгаа 2 хүн байгаа ба хамгийн богино ажилласан хүн 1 жил ба түүнээс урт хугацаанд ажиллаж байна. Нийт 3 ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 23, их нь 3948 өдөр ажилласан ба 28 хүн дунджаар тус албан тушаалд 837 хоног ажилласан байна. Ажиллаж байсан 28 хүний 14% нь 1 жил ба түүнээс бага хугацаанд ажилласан бол 86% нь 1.2 жилээс 10.8 жил хүртэл буюу харьцангуй тогтвортой ажилласан байна.

Судалгааны дүнгээр банкны үйл ажиллагааны үр дүнг голчлон хариуцах удирдлага болон удирдлагын багийн гишүүн нэг бүрийн ажилласан хугацаа тогтвортой бус, банкны үндсэн бүтээгдэхүүн болох томоохон төслийн хэрэгжилтийн үр дүнтэй холбон авч үзвэл ажиллах хугацааны гэрээний хэрэгжилт, ажлын үр дүнг тооцох тогтолцоо хангалтгүй үйлчилж ирсэн, нөгөө талаас хараат бус байдалд нөлөөлөхүйц байсан талаар Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах Түр хорооноос хийсэн “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт,

эргэн төлөлтийн явц, байдал"-ыг шалгасан шалгалтын тайланд дурджээ<sup>3</sup>.

Хөгжлийн банкны зохион байгуулалтын бүтэц, хүний нөөцийн хөдлөл өөрчлөлт өнгөрсөн хугацаанд дараах байдалтай байсан. Үүнд:

Хүснэгт 1. МУХБ-ны бүтцийн өөрчлөлт хүний нөөцийн хөдөлгөөн

| Д.д | Өөрчлөлт оруулсан тухай тогтоол, шийдвэр | Бүтэц (газар, нэгж, алба)            | Батлагдсан орон тоо | Ажиллаж буй орон тоо | Чөлөөлөгдсөн ажилтан | Шинээр ажилд орсон ажилтан |
|-----|--|--------------------------------------|---------------------|----------------------|----------------------|----------------------------|
| 1   | ТУЗ-ийн 2012 оны 10 дугаар тогтоол       | Газар – 4<br>Хэлтэс – 11             | 47                  | 78                   | 8                    | 35                         |
| 2   | ТУЗ-ийн 2012 оны 54 дугаар тогтоол       | Газар – 4<br>Хэлтэс – 12<br>Нэгж – 3 | 87                  | 79                   | 13                   | 14                         |
| 3   | ТУЗ-ийн 2014 оны 11, 12 дугаар тогтоол   | Газар – 5<br>Хэлтэс – 19<br>Алба – 1 | 168                 | 131                  | 20                   | 45                         |
| 4   | ТУЗ-ийн 2016 оны 69 дугаар тогтоол       | Газар – 4<br>Хэлтэс – 13<br>Алба – 1 | 149                 | 134                  | 33                   | 109                        |
| 5   | ТУЗ-ийн 2017 оны 91 дүгээр тогтоол       | Газар – 4<br>Хэлтэс – 13<br>Алба – 3 | 149                 | 146                  | 39                   | 59                         |
| 6   | ТУЗ-ийн 2019 оны 35 дугаар тогтоол       | Газар – 4<br>Хэлтэс – 13             | 149                 | 138                  | 66                   | 77                         |
| 7   | ТУЗ-ийн 2020 оны 16 дугаар тогтоол       | Газар – 6<br>Хэлтэс – 11             | 110                 | 106                  | 27                   | 19                         |
| 8   | ТУЗ-ийн 2021 оны 21 дүгээр тогтоол       | Газар – 5<br>Хэлтэс – 15<br>Алба – 2 | 131                 | 100                  | 41                   | 4                          |

Банкны бүтцийн нэгжүүдэд ажиллаж ирсэн болон чөлөөлөгдсөн, шинээр ажилд орсон ажилтнуудын тоо нийт батлагдсан орон тооны хэмжээнд харьцуулснаар өндөр хувьтай, тогтвортой бус байдалтай, энэ нь тухайн хугацаанд томилогдсон удирдлагын шийдвэртэй холбоотой, нөгөө талаас томилгоо дагасан хүний нөөцийн өөрчлөлт банкны үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулаагүй, засаглалын алдаанд хүргэсэн байна.

МУХБ-ны ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар тогтоолоор 2023 оны бизнес төлөвлөгөөг баталсан ч цаашид нөхцөл байдалтай уялдуулан алсын харааг тодорхойлох, урт болон дунд хугацаанд баримтлах стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга замыг боловсруулах шаардлагатай байсан.

Банкны үйл ажиллагаанаас зээл олголт, эргэн төлөлт, түүний орчинтой холбоотой үйл ажиллагаа залилангийн эрсдэлд өртөмтгий байдаг ч залилангийн эрсдэлийг тодорхойлж үнэлэх зохистой горим нэвтрүүлж, уг эрсдэлийг их гэж үнэлсэн тохиолдолд урьдчилан сэргийлэх, илрүүлэх тогтолцоо /горим журам/ үйлчлээгүй байсан.

Дээр дурдсан стратеги, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд залилантай тэмцэх стратегийг боловсруулж, залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, удирдах арга хэмжээг үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаж өгөх хэрэгтэй байсан.

<sup>3</sup> Хянан шалгах Түр хорооноос хийсэн “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдал"-ыг шалгасан шалгалтын тайлан., 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр дараах хаягт нийтлэгдсэн.

<https://www.parliament.mn/files/c02d669c1686437a83235768cd005000/?d=1>

Эдгээр нөхцөл байдалд үндэслэн Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 20 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайланда дурдсаны дагуу, Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн найруулгыг боловсруулсан байх тул тус хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд болон төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоог гаргах шаардлагатай болсон.

## **Хоёр.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдснаар хуулийн этгээдэд үүсэх зардал**

Энэ хэсэгт Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдснаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гарана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- нэг бүрийн зардлыг тооцох;
- тоон үзүүлэлтийг тооцох;
- нийт зардлын дүнг тооцож гаргах;
- хялбарчлах боломжийг шалгах;
- нэмэлт зардлыг тооцох.

### **2.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:**

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “Хөгжлийн банк” гэх)-ны зорилт, үйл ажиллагааны чиглэл, эрх хэмжээ, зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх санхүүгийн ажил, үйлчилгээний хүрээг тогтоож, эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.” гэж заажээ.

Үүнээс үзэхэд Хуулийн төсөл нь Монгол Улсын Хөгжлийн банкны эрх зүйн статус, чиг үүрэг, эрх хэмжээ, баримтлах зарчим, удирдлагын тогтолцоо зэрэг харилцааг зохицуулсан байх Монгол Улсын Хөгжлийн банкнаас өөр хуулийн этгээдэд зардал үүсгэхээргүй байна.

Монгол Улсын Хөгжлийн банк нь бие даасан хуулийн хүрээнд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг, үйл ажиллагааны орлого болон зардал нь төсвөөс санхүүждэггүй байх тул хуулийн төсөл батлагдсанаар тус банканд шинээр үүсэж буй үүргийг Хуулийн этгээдэд үүсэх зардалд тооцон энэхүү зардлын тооцоог хийх болно.

Түүнчлэн, одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2017 онд батлагдсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай<sup>4</sup> хуулиар банканд хүлээлгэсэн үүрэгтэй давхцаагүй, эсхүл өргөжүүлсэн үүргийг сонгох болно. Хуулийн төсөлд хуулийн этгээдэд зардал үүсгэх дараах шинэ болон өргөжүүлсэн үүрэг<sup>5</sup> байна. Үүнд:

<sup>4</sup> Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2017 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Хөгжлийн банкны үйл ажиллагааг одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар зохицуулж байх тул тус хуулийн төсөл дэх зарим үүргүүд нь шинээр бий болоогүй, эсхүл өргөжүүлээгүй байх бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд тухайллан заасан үүргүүд болно.

- Төлөөлөн удирдах зөвлөл банкны зохистой засаглалын журам, авлигын эсрэг, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох аргачлалыг баталж, мөрдөх;
- Төлөөлөн удирдах зөвлөл Хөгжлийн банканд хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хувьцаа эзэмшигчид жил бүр тайлагнах;
- Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, түүний гүйцэтгэлийн явц, хэрэгжилт болон судлагдаж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэх;

зэрэг үүргийг гүйцэтгэхэд хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцоолох болно.


Дээрх үүргүүдийг хуулийн төсөлд дараах байдлаар тодорхойлсон байна.

*Хүснэгт 2.Хуулийн төсөлд шинээр нэмэгдэж буй Хөгжлийн банкны үүрэг*

| №/д | Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт   | Үүрэг  | Тайлбар  |
|-----|---|--|--|
| 1   | /Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1.14 дэх заалт/<br><br>30.1.14.Хөгжлийн банкны зохистой засаглалын журам, авлигын эсрэг, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох аргачлалыг баталж, мөрдүүлэх;  | Хөгжлийн банкны зохистой засаглалын журам, авлигын эсрэг, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох аргачлалыг баталж, мөрдүүлэх;  | Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар тус журам, аргачлалыг батлах талаар тусгаагүй байна.  |
| 2   | /Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалт/<br><br>30.1.15.Хөгжлийн банканд хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хувьцаа эзэмшигчид жил бүр тайлагнах;                               | Хөгжлийн банканд хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хувьцаа эзэмшигчид жил бүр тайлагнах;                                      | Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар хяналт шалгалтаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн тайлагнах үүргийн талаар тусгаагүй байна.  |
| 3   | /Хуулийн төслийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг/<br><br>44.4.Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, түүний гүйцэтгэлийн явц, хэрэгжилт болон судлагдаж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэх. | Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, түүний гүйцэтгэлийн явц, хэрэгжилт болон судлагдаж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэх; | Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, түүний гүйцэтгэлийн явц, хэрэгжилт болон судлагдаж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэх үүргийн талаар тусгаагүй байна. |

## 2.2.Нэг бүрийн зардлыг тооцох:

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах мөнгөн зардлыг тооцоолон гаргана. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:



Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлоходоо аргачлалын гарын авлагад бичигдсэн стандарт үйл ажиллагааны жагсаалтын дундаж хугацааг жишиг болгон авсан болно.

*Хүснэгт 3. Хуулийн төслийн нэмээдэж буй үүрэгийг билеулэхэд зарцуулах хугацаа*

| № | Гүйцэтгэх үүрэг  | Үүргийн агуулга   | Стандарт үйл ажиллагаа  | Зарцуулах хугацаа |
|---|--|---|---|-------------------|
| 1 | /Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1.14 дэх заалт/  | Хөгжлийн банкны зохистой засаглалын журам, авлигын эсрэг, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох аргачлалыг баталж, мөрдүүлэх;   | Хөгжлийн банкны зохистой засаглалын журам, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох аргачлалыг судалж боловсруулах | 80 цаг            |
|   |  |   | Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж батлах   | 8 цаг             |
|   |  |   | Мөрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах   | 80 цаг            |
| 2 | /Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалт/ | Хөгжлийн банканд хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хувьцаа эзэмшигчид жил бүр тайлгахнах;                                      | Мэдээлэл цуглуулах  | 16 цаг            |
|   |  |   | Мэдээллийг нэгтгэн боловсруулах   | 16 цаг            |
|   |  |   | Мэдээллийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээдэд хүргүүлэх   | 4 цаг             |
| 3 | /Хуулийн төслийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг/     | Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, түүний гүйцэтгэлийн явц, хэрэгжкилт болон судлагдаж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэх; | Мэдээлэл цуглуулах  | 16 цаг            |
|   |  |   | Цуглуулсан мэдээллийг нэгтгэн боловсруулах  | 24 цаг            |
|   |  |   | Мэдээллийг цахим сайтад байршуулах  | 30 минут          |

**Ажлын хөслүүлэх** тооцож гаргахдаа ажилтанд олгох сарын үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааж ажлын хөслүүлэх өдөр, цаг, минутаар гаргана. Хөгжлийн банкны нэг ажилтанд оногдох дундаж сарын цалин 3,165,454 төгрөг байна. Ажиллах хугацааг тооцоолоходоо Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн цагийг үндэслэв.

| <b>Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа</b>   |  |
|---|--|
| 3,165,454 : 22 өдөр : 8 цаг : 60 минут = <b>209.8</b> төгрөг /нэг минутын хөдөлмөрийн хөлс/ |  |

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд Хөгжлийн банканд үүсгэж байгаа зардлыг үйл ажиллагаа тус бурд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх замаар тооцоолох юм.

*Хүснэгт 4. Хөгжлийн банканд үүсгэж байгаа зардлыг үйл ажиллагаа тус бурд зарцуулж буй нэг бүрийн зардал*

| д/д | Гүйцэтгэх үүрэг   | Зарцуулах хугацаа | Ажлын хөлс /минутаар/ | Нэг бүрийн зардал |
|-----|---|-------------------|-----------------------|-------------------|
| 1   | Хөгжлийн банкны зохистой засаглалын журам, авлигын эсрэг, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох аргачлалыг баталж, мөрдүүлэх;   | 10,080 минут      | 209.8                 | 2,114,784         |
| 2   | Хөгжлийн банканд хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хувьцаа эзэмшигчид жил бүр тайлгахнах;                                      | 2,160 минут       | 209.8                 | 451,224           |
| 3   | Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, түүний гүйцэтгэлийн явц, хэрэгжкилт болон судлагдаж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэх; | 2,430 минут       | 209.8                 | 507,627           |

### 2.3. Тоон үзүүлэлтийг тогтоох:

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хуулийн этгээдэд жилд хэдэн удаагийн давтамжтай хүлээлгэж байгаагаар илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцоходоо тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлнэ.

Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо /Тохиолдлын тоо/
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо /Давтамжийн тоо/

Тохиолдлын тоог тогтоохдоо хуулиар үүрэг хүлээж байгаа хуулийн этгээдийн төрлийг харгалzan үзэх шаардлагатай. Хэрэв тухайн хуулийн зохицуулалт хуулийн этгээдийн хэд хэдэн төрлийг хамарч байвал тэдгээр төрөл тус бүрийн оролцогчийн тоог гаргана.

Хуулийн төслөөс үзэхэд тус хууль нь агуулгын хувьд Хөгжлийн банкны эрх байдлыг тогтоосон шинжтэй байх тул шинээр бий болсон үүргүүд нь зөвхөн Хөгжлийн банканд хамаарах үүргүүд байна. Иймд тохиолдлын тоог нэгжээр тооцов.

Давтамжийг тооцохдоо өмнөх үе шатуудад тогтоосон Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан гарснаар шинээр болж буй үүргүүдийг Хөгжлийн банк нь жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Энэ үзүүлэлтийг гаргахын тулд тохиолдлын тоо болон давтамжийг холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм.

### ТОХИОЛДЛЫН ТОО х ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Дээрх томъёог ашиглан хуулийн төсөл батлагдснаар шинээр нэмэгдэж байгаа гэж тодорхойлогдсон үүрэг тус бүрд тоон үзүүлэлтийг тогтоодог.

Хөгжлийн банкнаас харилцагчийг таньж мэдэх ажиллагааг холбогдох газар, хэлтэс чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж 2022 онд нийт харилцагч зээлдэгчийн давхардсан тоогоор 130 байгууллага, 5918 иргэн түүний хамаарал бүхий аж ахуйн нэгж, хувь хүний мэдээллийг дотоод хайлтын систем болон бусад эх сурвалжтай тулган баталгаажуулж, эцсийн өмчлөгчийг тогтоох чиглэлээр комплаенсын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажилласан байна.<sup>6</sup>

Үүнээс гадна Монгол Улсын Хөгжлийн банкнаас нийт харилцагчийн түүхэн тоон мэдээллийг дараах байдлаар ирүүлсэн.

| Харилцагчийн тоо                 |           |           |           |           |           |           |           |
|----------------------------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| Он                               | 2017      | 2018      | 2019      | 2020      | 2021      | 2022      | 2023      |
| <b>Хадгаламж</b>                 | 5         | 4         | 8         | 2         | 3         | 3         | 2         |
| <b>Үүсмэл санхүүгийн хөрөнгө</b> | 1         | 4         | 4         | 3         | 2         | 2         | 1         |
| <b>Зээл</b>                      | 62        | 73        | 74        | 72        | 66        | 52        | 40        |
| <b>Үнэт цаас</b>                 | 1         | 4         | 3         | 7         | 6         | 7         | 4         |
| <b>ӨБҮХХ</b>                     | -         | 5         | 5         | 5         | 7         | 10        | 9         |
| <b>Нийт</b>                      | <b>69</b> | <b>90</b> | <b>94</b> | <b>89</b> | <b>84</b> | <b>74</b> | <b>56</b> |

<sup>6</sup> Монгол Улсын Хөгжлийн банкны 2022 оны жилийн тайлан. /34 дэх тал/ [https://dbmmn.s3.us-west-1.amazonaws.com/Reports/DBM\\_annual\\_report\\_2022\\_new\\_finish.pdf](https://dbmmn.s3.us-west-1.amazonaws.com/Reports/DBM_annual_report_2022_new_finish.pdf) сүүлд үзсэн 2024.03.17

Эдгээр харилцагч, зээлдэгчийн тоон мэдээллээс харахад жилд дунджаар 62.7 хуулийн этгээдтэй зээлийн гэрээ байгуулан харилцдаг байх тул Хөгжлийн банк нь 1 жилд 63 хуулийн этгээдтэй зээлийн гэрээ байгуулан харилцдаг гэж тооцон тохиолдлын тоог гарган авлаа.

Хуулийн төслөөс үзэхэд Хөгжлийн банкны зохистой засаглалын журам, авлигын эсрэг, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох аргачлалыг баталж, мөрдүүлэх үүрэг нь хамгийн багадаа хоёр журам, аргачлал баталж мөрдүүлэх, мөн дагалдан гарах бусад баримт бичгүүдийг боловсруулж батлан мөрдүүлэхээр байх тул тохиолдлын тоог З байхаар тооцов.

Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, түүний гүйцэтгэлийн явц, хэрэгжилт болон судлагдаж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэх үүргийн хувьд давтамжийн тодорхойлоходоо Хөгжлийн банкнаас жилд харилцдаг харилцагчийн тоогоор тооцов.

Хөгжлийн банканд хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хувьцаа эзэмшигчид жил бүр тайлагнах үүргийн хувьд хууль жил бүр хэмээн давтамжийн тоог тодорхойлсон байна.

## 2.4. Нийт захиргааны зардлын дүнг тооцож гаргах:

Энэ үе шатанд өмнөх үе шатанд гаргасан үүрэг тус бүрд ногдох нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлснээр гаргах юм.

### НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ х ТООН ҮЗҮҮЛЭЛТ = НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 5. Нийт зардал

| д/д | Гүйцэтгэх үүрэг  | Нэг бүрийн зардал | Тохиолдлын тоо | Нийт зардал <sup>7</sup> |
|-----|--|-------------------|----------------|--------------------------|
| 1   | Хөгжлийн банкны зохистой засаглалын журам, авлигын эсрэг, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох аргачлалыг баталж, мөрдүүлэх;  | 2,114,784         | 3              | 6,344,352                |
| 2   | Хөгжлийн банканд хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хувьцаа эзэмшигчид жил бүр тайлагнах;                                      | 451,224           | 1              | 451,224                  |
| 3   | Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, түүний гүйцэтгэлийн явц, хэрэгжилт болон судлагдаж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэх; | 507,627           | 63             | 31,980,501               |
|     | НИЙТ ЗАРДАЛ  | 3,073,635         | 67             | 38,776,077               |

## 2.5. Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийн талаар

Хуулийн төслөөр хуулийн этгээдэд хүлээлгэсэн мэдээлэл хүргүүлэх үүргийг цахимаар шийдвэрлэвэл хуулийн этгээдэд үүсэх зардлыг багасгах, хялбарчлах боломжтой гэж үзэж байна.

Хөгжлийн банк нь өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм журмыг боловсруулах, батлах, мөрдүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг тул холбогдох дүрэм журмыг боловсруулж батлах, мөрдүүлэх үйл ажиллагааг өнөөгийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан гүйцэтгэх замаар дээрх зардлыг бууруулах боломжтой гэж үзлээ.

<sup>7</sup> "Нийт зардал" гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх нийт хуулийн этгээдэд дээрх үүргийг гүйцэтгэхэд нэг удаад үүсэх захиргааны зардал болно.

## **2.6.Нэмэлт зардлыг тооцох:**

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх хүрээнд Хөгжлийн банкнаас хуульд заасан үүргийг биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хуулиар тогтоосон төлбөр хураамж, тоног төхөөрөмж, материал зэргийг нэмэлт зардал гэсэн ойлголтонд хамруулах юм.

Хуулийн төсөлд зааснаас үзвэл, Хөгжлийн банканд нэмэлт зардал үүсэхээр зохицуулалт байхгүй байх бөгөөд Хөгжлийн банк нь одоо байгаа материал, тоног төхөөрөмжийн хүрээнд хуулийн төсөлд шинээр тусгасан үүргийг хэрэгжүүлэх боломжтой.

## **ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Энэ бүлэгт Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн төрийн захиргааны байгууллагад үүрэг оногдуулсан зарим зохицуулалтууд нь төрд ямар ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцоолох юм. Захиргааны байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хуулийн зохицуулалтын хэрэгжих боломжийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм.

Иймд энэхүү судалгаагаар шинээр нэмэгдэж буй чиг үүргийг хэрэгжүүлэхэд улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолох ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

- 3.1. Шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;
- 3.2. Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- 3.3. Нийт хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох
- 3.4. Бусад зардал;
- 3.5. Зардлыг нэгтгэн тооцох;
- 3.6. Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

### **3.1.Шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;**

Хуулийн төслийн зохицуулалтаас үзвэл, хуулийн төслийн хэрэгжилтийг хангахад гол чиг үүргийг хүлээгч байгууллага нь Монгол Улсын засгийн газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Монголбанк байна.

Хуулийн төслийн зургаа дугаар бүлэгт Хөгжлийн банкны талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, хамтын ажиллагааг зохицуулсан байх бөгөөд мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурал Хөгжлийн банкны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Засгийн газар Хөгжлийн банкны талаар Компанийн тухай хуулийн 62.1-д заасан хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт “Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөгжлийн банкны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Монголбанк нь Хөгжлийн банкны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан байна.

Эдгээр зүйлүүдийн агуулгыг хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дөрөв дүгээр бүлэгтэй харьцуулж үзвэл дараах үүргүүдийг шинээр тусгасан байна.

**Хүснэгт 6. Төрийн байгууллагаад шинээр нэмэгдэж буй үүрэг**

| д/д | Төрийн байгууллагын нэр  | Хуулийн төсөлд тусгасан байдал  | Шинээр нэмэгдсэн эсхүл өргөжүүлсэн үүрэг   |
|-----|--|---|--|
| 1   | Улсын Их Хурал   | -   | Байхгүй  |
| 2   | Засгийн газар  | <p>10.3.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд хувьцаа эзэмшигч өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.</p> <p>35.1.11.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд энэ хуулийн дагуу болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу хийсэн хөндлөнгийн хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн дүгнэлт, тайланг Монгол Улсын Их Хуралд хүргүүлэх;</p> <p>35.2.Засгийн газар Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, тэдгээрийг хэрэгжүүлэх этгээдийн жагсаалтыг тусгайлан батлахгүй бөгөөд санхүүжилт олгох зорилтот салбарыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг батална.</p> <p>35.3.Хөгжлийн банкны алдагдлыг бууруулах зорилгоор Засгийн газраас тус банкны тогтвортой байдал, тасралтгүй үйл ажиллагааг хангахад шаардлагатай дараах санхүүгийн дэмжлэгийг үзүүлж болно.</p> <p>35.3.1.өөрийн хөрөнгөд нэмэлт хөрөнгө оруулах;</p> <p>35.3.2.Өрийн удирдлагын хуульд заасны дагуу өрийн баталгаа гарах;</p> <p>35.3.3.зээл олгох.</p> | Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хэмжээ буурсан тохиолдолд заавал нэмэгдүүлэх асуудал нь хүчин төгөлдөр хуулиар зохицуулагдаагүй.<br>Хөндлөнгийн хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн дүгнэлт, тайланг Монгол Улсын Их Хуралд хүргүүлэх асуудал хүчин төгөлдөр хуулиар зохицуулагдаагүй.<br>Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, тэдгээрийг хэрэгжүүлэх этгээдийн жагсаалтыг тусгайлан батлахгүй бөгөөд санхүүжилт олгох зорилтот салбарыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг батлах асуудал хүчин төгөлдөр хуулиар зохицуулагдаагүй. |
| 3   | Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага        | 35.5.Энэ хуулийн 35.3-т заасан дэмжлэгийг Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон тухайн жилийн төсвийн хуульд нийцүүлэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авна.   | Хөгжлийн банкны алдагдлыг бууруулах зорилгоор Засгийн газраас тус банкны тогтвортой байдал, тасралтгүй үйл ажиллагааг хангахад шаардлагатай дараах санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх асуудал хүчин төгөлдөр хуулиар зохицуулагдаагүй.  |
| 4   | Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | 36.1.4.Хөгжлийн банкны санхүүжилт олгох зорилтот салбарыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газраар батлуулах.  | Хөгжлийн банкны санхүүжилт олгох зорилтот салбарыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газраар батлуулах асуудал хүчин төгөлдөр хуулиар зохицуулагдаагүй.  |
| 5   | Монголбанк   | <p>11.4.Монголбанк нь энэ хуулийн 37.1.4-д заасан журмыг батлахдаа Хөгжлийн банкны зорилт, экспортыг дэмжих бодлогод нийцэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр татан төвлөрүүлсэн гадаад валютын эх үүсвэрийн ханшийн эрсдэлийг зардалгүй удирдахаар зохицуулна.</p> <p>37.1.Монголбанк нь Хөгжлийн банкны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>37.1.2. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төслийн эдийн засгийн үр ашгийг тооцож, үнэлэх асуудал хүчин төгөлдөр хуулиар зохицуулагдаагүй.</p> <p>37.1.Монголбанк нь Хөгжлийн банкны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>37.1.4.Хөгжлийн банкны гадаад валютаар татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зах зээлийн эрсдэлийг удирдахад дэмжлэг үзүүлж, тусгай нөхцөл бүхий санхүүгийн хэрэгсэл ашиглах журмыг батлах асуудал хүчин төгөлдөр хуулиар зохицуулагдаагүй.</p>  | Хөгжлийн банкны гадаад валютын эх үүсвэрийн ханишийн эрсдэлийг зардалгүй удирдахад Монголбанкаас дэмжлэг үзүүлэх асуудал хүчин төгөлдөр хуулиар зохицуулагдаагүй.<br>Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төслийн эдийн засгийн үр ашгийг тооцож, үнэлэх асуудал хүчин төгөлдөр хуулиар зохицуулагдаагүй.<br>Хөгжлийн банкны гадаад валютаар татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зах зээлийн эрсдэлийг удирдахад дэмжлэг үзүүлж, тусгай нөхцөл бүхий санхүүгийн хэрэгсэл ашиглах журмыг батлах асуудал хүчин төгөлдөр хуулиар зохицуулагдаагүй.   |

**Иймээс энэхүү судалгаагаар дээрх нэмэгдэж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал, ачааллыг тооцоолов.**

**3.2.Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;**

Хуулийн төсөл дэх төрийн байгууллагад хүлээлгэсэн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах ажил, үйлчилгээ тус бүрийг стандарт үйл ажиллагааны загварын дагуу тооцож, хэдий хэмжээний цаг хугацаа зарцуулахыг тогтоох юм. Хугацааг тодорхойлсноор тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тогтоох бөгөөд улмаар улсын төсөвт хүний нөөцтэй холбоотой ямар хэмжээний зардал нэмэгдэхийг урьдчилан тооцох боломжтой. Хүний нөөцийн хэрэгцээг тооцоходо тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон 1 жилд гүйцэтгэх тохиолдлын тоогоор баримжаалдаг. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, ачааллын онцлогт тохирсон стандарт үйл ажиллагаа болон түүнд шаардагдах хугацааг нэгдсэн байдлаар тогтоосон зүйлгүй байна.

Иймд тохиолдлын тоог тогтооходо тухай бүр болон тодорхойлох боломжгүй тохиолдол бүрд жилд нэг удаа байхаар тооцов. Мөн тус чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацааг тооцоходо олон тооны ажилтан ажиллахыг харгалзан үзэж нэг ажилтан дунджаар дөрвөн долоо хоног зарцуулахаар тооцов.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулах авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

- 1 жил = ажлын 200<sup>8</sup> өдөр
- 1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/
- 1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу  $200 \times 8 / 1600$  ажлын цаг буюу  $1,600 \times 60 / 96000$  минут ажиллана гэсэн үг.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг нэг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу ажлын байрны тоо гарна. Үүнийг дараахь байдлаар гаргана.

*Хүснэгт 6. Төрийн байгууллагад шинээр нэмэгдэж буй үүрэг*

| Д/д | Төрийн байгууллагын нэр   | Гүйцэтгэх үүрэг  | Зарцуулах үйл ажиллагаа/минут | Тохиолдлын тоо | Нийт хугацаа |
|-----|---|--|-------------------------------|----------------|--------------|
| 1   | Засгийн газар   | Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хэмжээ буурсан тохиолдолд заавал нэмэгдүүлэх  | 160 цаг                       | Тухай бүр      | 160 цаг      |
|     |   | Хөндлөнгийн хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн дүгнэлт, тайланг Монгол Улсын Их Хуралд хүргүүлэх  | 2 цаг                         | Жилд 1 удаа    | 2 цаг        |
|     |   | Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, тэдгээрийг хэрэгжүүлэх этгээдийн жагсаалтыг тусгайлан батлахгүй бөгөөд санхүүжилт олгох зорилтот салбарыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг батлах | 160 цаг                       | Тухай бүр      | 160 цаг      |
|     |   | Хөгжлийн банкны алдагдлыг бууруулах зорилгоор Засгийн газраас тус банкны тогтвортой байдал, тасралтгүй үйл ажиллагааг хангахад шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх.                                       | 160 цаг                       | Тухай бүр      | 160 цаг      |
| 2   | Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | Хөгжлийн банкны алдагдлыг бууруулах зорилгоор Засгийн газраас тус банкны тогтвортой байдал, тасралтгүй үйл ажиллагааг хангахад шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх  | 160 цаг                       | Тухай бүр      | 160 цаг      |
| 3   | Эдийн засаг,  | Хөгжлийн банкны санхүүжилт олгох зорилтот  | 160 цаг                       | Тухай бүр      | 160 цаг      |

<sup>8</sup> Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

|   |   |   |         |           |         |
|---|---|---|---------|-----------|---------|
|   | хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага | салбарыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газраар батлуулах            |         |           |         |
| 4 | Монголбанк  | Хөгжлийн банкны гадаад валютын эх үүсвэрийн ханшийн эрсдэлийг зардалгүй удирдахад Монголбанкаас дэмжлэг үзүүлэх   | 160 цаг | Тухай бүр | 160 цаг |
|   |   | Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төслийн эдийн засгийн үр ашгийг тооцож, үнэлэх  | 10 цаг  | Тухай бүр | 10 цаг  |
|   |   | Хөгжлийн банкны гадаад валютаар татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зах зээлийн эрсдэлийг удирдахад дэмжлэг үзүүлж, тусгай нөхцөл бүхий санхүүгийн хэрэгсэл ашиглах журмыг батлах | 160 цаг | Тухай бүр | 160 цаг |

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар **1328.1** мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 203.8 (15.3 %) мянган төгрөгөөр нэмэгдсэн<sup>8</sup> бол төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн нэг ажилтны сарын цалингийн жигнэсэн дундаж **1,580.0** мянган төгрөг, улсын төсөвт үйлдвэрийн газрын ажиллагсдын сарын дундаж цалин **1.063.0** мянган төгрөг байна.<sup>9</sup> Төрийн өмчит аж ахуйн нэгжийн нэг сарын дундаж цалин улсын дундаж цалингаас 18 хувиар илүү, харин улсын төсөвт үйлдвэрийн газрын ажилтны сарын дундаж цалин улсын дундаж цалингаас 20 хувиар бага байна.

Иймд бодит байдал дээр төрийн өмчит аж ахуйн нэгжийн ажилтны сарын дундаж цалин нь улсын дундаж цалингаас дээгүүр, харин улсын төсөвт үйлдвэрийн газрын ажилтны сарын дундаж цалин нь улсын дундаж цалингаас доогуур байгаа тул төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн болон улсын төсөвт үйлдвэрийн газрын ажиллагсдын жигнэсэн дундаж цалингийн дундаж үзүүлэлтийг тооцоолон зардлын тооцоонд үндэслэл болгов. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит аж ахуйн нэгжийн нэг ажилтны сарын цалингийн жигнэсэн дундаж **1,580.0** мянган төгрөг + улсын төсөвт үйлдвэрийн газрын ажиллагсдын сарын дундаж цалин **1,063.0** мянган төгрөг : 2 = **1,321.5** мянган төгрөг төрийн байгууллагын нэг ажилтны сарын дундаж цалин байхаар тооцов. Энэ нь улсын дундаж цалин болох **1,328.1** мянган төгрөгтэй ойролцоо байна.

Иймд Төрийн байгууллагын нэг ажилтны дундаж цалинг цагаар тооцохдоо **1,321.5/176=7,508.5** буюу 1 ажилтан 1 цагт **7,508.5** төгрөгийн цалинтайгаар ажиллахаар тооцов.

Үүнээс үзэхэд хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллагуудад шинээр нэмэгдэж буй чиг үргийг хэрэгжүүлэхэд дараах зардлууд гарахаар байна.

| д/д | Төрийн байгууллагын нэр | Гүйцэтгэх үүрэг  | Зарцуулах үйл ажиллагаа/минут | Төрийн байгууллагын дундаж цалин | Нийт зардал   |
|-----|-------------------------|--|-------------------------------|----------------------------------|---------------|
| 1   | Засгийн газар           | Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хэмжээ буурсан тохиолдолд заавал нэмэгдүүлэх  | 160 цаг                       | 7,508.5                          | 1,201.3 мянга |
|     |                         | Хөндлөнгийн хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн дүгнэлт, тайланг Монгол Улсын Их Хуралд хүргүүлэх  | 2 цаг                         | 7,508.5                          | 15.0 мянга    |
|     |                         | Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, тэдгээрийг хэрэгжүүлэх этгээдийн жагсаалтыг тусгайлан батлахгүй бөгөөд санхүүжилт олгох зорилtot салбарыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг батлах | 160 цаг                       | 7,508.5                          | 1,201.3 мянга |
|     |                         | Хөгжлийн банкны алдагдлыг бууруулах зорилгоор Засгийн газраас тус банкны тогтвортой байдал, тасралтгүй үйл ажиллагааг хангахад шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх.                                       | 160 цаг                       | 7,508.5                          | 1,201.3 мянга |

|   |  |  |         |         |               |
|---|--|--|---------|---------|---------------|
| 2 | Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага        | Хөгжлийн банкны алдагдлыг бууруулах зорилгоор Засгийн газраас тус банкны тогтвортой байдал, тасралтгүй үйл ажиллагааг хангахад шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх                                    | 160 цаг | 7,508.5 | 1,201.3 мянга |
| 3 | Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | Хөгжлийн банкны санхүүжилт олгох зорилtot салбарыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газраар баттуулах | 160 цаг | 7,508.5 | 1,201.3 мянга |
| 4 | Монголбанк   | Хөгжлийн банкны гадаад валютын эх үүсвэрийн ханшийн эрсдэлийг зардалгүй удирдахад Монголбанкнаас дэмжлэг үзүүлэх   | 160 цаг | 7,508.5 | 1,201.3 мянга |
|   |  | Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төслийн эдийн засгийн үр ашгийг тооцож, үнэлэх   | 10 цаг  | 7,508.5 | 75.0 мянга    |
|   |  | Хөгжлийн банкны гадаад валютаар татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зах зээлийн эрсдэлийг удирдахад дэмжлэг үзүүлж, тусгай нөхцөл бүхий санхүүгийн хэрэгсэл ашиглах журмыг батлах                                | 160 цаг | 7,508.5 | 1,201.3 мянга |

### 3.3. Нийт хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох

Хуулийн төслийн зохицуулалтаас үзвэл, хуулийн төслийн хэрэгжилтийг хангахад гол чиг үүргийг хүлээгч байгууллага нь Монгол Улсын засгийн газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Монголбанк байна.

Одоо хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль, Монголбанкны тухай хууль зэрэг хуулиудаар дээрх төрийн байгууллагууд нь Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох дүрэм журмыг батлах чиг үүрэгтэй байгууллагууд байна.

Иймд эдгээр байгууллага нь одоогийн хүний нөөцийн боломжоороо эдгээр хяналтын чиг үүргийг биелүүлэх боломжтой гэж үзэж байна.

### 3.4. Бусад зардал

Бусад зардалд төрийн байгууллагаас тухайн ажил үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагалдан гарах зардлыг авч үзнэ. Тухайлбал байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх, тусгайлсан програм хангамж боловсруулах, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нэн шаардлагатай бараа материал худалдан авах гэх зэрэг зардлыг нэмэгдүүлэх чиг үүрэг шинээр нэмэгдээгүй байна.

Хуулийн төслөөс үзэхэд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх, тусгайлсан програм хангамж боловсруулах, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нэн шаардлагатай бараа материал худалдан авах гэх зэрэг зардлыг нэмэгдүүлэх чиг үүрэг шинээр нэмэгдээгүй байна.

Иймд хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор бусад зардал гарахгүй байх боломжтой гэж үзэж байна.

### 3.5. Зардлыг нэгтгэн тооцох

Энэ үе шатанд төрийн захиргааны байгууллагаас буюу төрд үүсэх нийт зардлыг тооцож гаргана. Ингэхдээ хүний нөөцийн зардал, материаллаг зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн тооцох ба үүн дээр бусад зардлыг

нэмснээр нийт зардлын хэмжээ гарах юм. Энэ тохиолдолд дурдсан шинээр нэмэгдэж буй чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд шинээр хүний нөөцийн хэрэгцээ байхгүй буюу дурдсан байгууллагууд одоогийн хүний нөөцийн боломжоороо хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн, хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор бусад зардал гарахгүй гэж үзсэн тул Хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор төрийн байгууллагад зардал үүсэхгүй гэж үзлээ.

### **3.6.Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах**

Хуулийн төсөл батлагдсанаар батлагдсантай холбоотойгоор улсын төсөвт зардал үүсэхгүй гэж үзсэн тул хувилбарыг нягталж, хялбарчлах шаардлагагүй гэж үзлээ.

## **ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, САНАЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>9</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан зардлын тооцоог гаргалаа.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдахаас өмнө буюу одоогоор Хөгжлийн банк нь 2017 онд батлагдсан монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан тодорхой үүргийг хүлээж байгаа болно.

Хуулийн төсөлд тусгагдсан зардлыг тооцохын тулд бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалан авах зэрэгээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон бөгөөд тухай бүрт тайлбарыг оруулсан болно.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу иргэнд үүсэх зардал нь цаг хугацаагаар, хуулийн этгээдэд үүсэх зардал нь мөнгөн дүнгээр, төрийн байгууллагад үүсэх зардал нь хүний нөөцийн хэрэгцээгээр тооцогдог. Эдгээр тооцож гаргасан зардлууд дээр “бусад зардал”, “нэмэлт зардал” буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх зардлыг мөн тооцсон болно.

Хуулийн төслийн зохицуулалтаар буюу хуулийн төсөл батлагдсанаар зардал үүсгэгч этгээд болох Монгол Улсын Хөгжлийн банк болон төрийн байгууллагад тодорхой үүрэг бий болгосон, түүнийг хэрэгжүүлэхэд мөнгөн зардал бий болохор тусгагдсан байна.

Одоо дагаж мөрдөж байгаа Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан хөгжлийн банк болон төрийн байгууллагуудад хүлээлгэсэн үүргүүдтэй хуулийн төсөл дэх адил төстэй үүргүүдэд зардал тооцоогүй бөгөөд шинээр бий болж байгаа үүргүүдэд зардлыг тооцоолов.

Харин дээрх заалтыг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардал захиргааны зардал Хөгжлийн банкны хувьд 38,776,077 төгрөг байхаар байна. Үүнийг хялбарчлахын тулд Хөгжлийн банк нь өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм журмыг боловсруулах, батлах, мөрдүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг тул холбогдох дүрэм журмыг боловсруулж батлах, мөрдүүлэх үйл ажиллагааг өнөөгийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан гүйцэтгэх замаар дээрх зардлыг бууруулах боломжтой гэж үзлээ.

Хуулийн төсөл нь улсын төсөвт хүний нөөцийн болон бусад зардал зардлыг тооцоолов.

<sup>9</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын үр өгөөж нь зардлаасаа их байна. Учир нь хуулийн төсөл батлагдсанаар Хөгжлийн банк нь нээлттэй, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулж Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх үйл ажиллагааг дэмжин, нийтэд санал болгох, Хөгжлийн банкны засаглал, шийдвэр гаргах эрх хэмжээг тодорхой болгон оновчтой хуваарилах, санхүүжилт авсан этгээдийн эдийн засгийн болон бусад хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэгтэй холбогдсон харилцааг шинээр зохицуулж, экспорт импорт, худалдааны санхүүжилтийн үйл ажиллагааг тулхүү хэрэгжүүлж, бизнесийн орчныг дэмжих чиглэсэн тодорхой зохицуулалт тусган боловсруулсан байх тул нийгэм, эдийн засагт эерэг үр өгөөжтэй байна.

оОо

## **АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

### **Хууль тогтоомж, эрх зүйн акт**

1. Хууль тогтоомжийн тухай хууль
2. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль
3. Хөдөлмөрийн тухай хууль
4. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр торгтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал"

### **Бусад ашигласан материал**

1. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал
2. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эхний хувилбар
3. Хуулийн төслийн таницуулга
4. Үндэсний аудитын газрын 2015 онд хийсэн бие даасан шалгалт тайлан;
5. Засгийн газраас 2016 онд хийсэн хамтарсан шалгалтын тайлан;
6. Үндэсний аудитын газраас 2017 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;
7. Монголбанкаас 2017 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;
8. Монголбанкаас 2018 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;
9. Үндэсний аудитын газраас 2019 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;
10. Засгийн газраас 2019 онд хийсэн хамтарсан шалгалтын тайлан;
11. Монголбанкаас 2021 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;
12. УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн 2022 онд хийсэн хамтарсан шалгалтын тайлан.
13. УИХ-ын хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны тайлан 2023 он;
14. Үндэсний аудитын газраас 2023 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;

### **Цахим эх сурвалж**

1. <http://www.legalinfo.mn>
2. Үндэсний статистикийн хорооны [www.nso.mn](http://www.nso.mn) веб хуудас.